



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/58

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “д”, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах 4 тусгай зөвшөөрөлтэй байгууллагын халаалтын зуухны үйл ажиллагааг хянан шалган зуухны сүлжээний усны алдагдал бууруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Анхбаяр	(Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Б.Бямбасүрэн	(Орон нутгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
Гишүүд:	С.Бат-Оргил	(Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч)
	О.Мөнхзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Золжаргал	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
	Ц.Доржпүрэв	(Аймгийн Онцгой байдлын Газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч)
	Г.Далх	(Аймгийн Цагдаагийн газрын Эргүүлийн цагдаагийн дэд ахлагч)
	Э.Эрдэнэбат	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
	Г.Буянбат	(Сайнцагаан сумын Нарлаг багийн Засаг дарга)
	Б.Уламбаяр	(“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын ашиглалтын инженер)

481210140

О.Ганхуяг	("Ган-Илч" ХХК-ийн гүйцэтгэх захирал)
Э.Дашням	("Ган-Илч" ХХК-ийн ерөнхий инженер)
Б.Батнаран	("Тэвшийнговь" ХХК-ийн дулааны хэсгийн дарга)
Ө.Эрдэнэтунгалаг	("Говь сервис" СӨХолбооны дарга)
Н.Батбаяр	(Сайнцагаан сумын Нарлаг багийн иргэн, иргэний төлөөлөл)

2. Ажлын хэсэг халаалтын зуухны үйл ажиллагааны галлагаа, усны алдагдал, нүүрсний нөөц, цахилгааны нөөц эх үүсвэр, ажилчдын хамгаалалтын хувцас, хэмжих хэрэгсэл (термометр, манометр, цэвэр усны тоолуур), хүний нөөцөд хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулан 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулан дүгнэлтийг танилцуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/367 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ